

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Нэг: Аймгийн Онцгой комиссын хүрээнд:** Улсын Онцгой комиссын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны хуралдаанаар баталсан Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын ажиллах журам, Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай хууль тогтоомжууд, Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэл, албан даалгавар болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аймгийн Онцгой комиссоос 2021 оны 04 дүгээр сард дараах ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой комисс 2021 оны 04 дүгээр сарын байдлаар 5 удаа хуралдаж аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 21 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 3 тогтоол, аймгийн Засаг даргын 2 захирамж, Онцгой комиссын даргын 2 тушаал, АОК-ын дэргэдэх шуурхай штабын 2 шийдвэр, 3 тогтоол үүрэг хүргүүлэх болон холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллав.

Улаанбаатар хот болон бусад аймгаас орон нутагтаа ирэх, буцах, /эрүүл мэнд буяны ажил/-тай, албан томилолт, хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, өвс тэжээл, уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалан, зам барилга бүтээн байгуулалтын тээвэрлэлт хийх тухай хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт холбогдох бичиг баримтуудыг цахимаар хүлээн авч судалж шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын дагуу нэвтрүүлэх, зөвшөөрөл олгоход онцгой анхаарч албан бичгээр ирэх зөвшөөрөл, аймгийн Онцгой комиссын тусгай зөвшөөрлөөр иргэн, тээврийн хэрэгслийг гаргаж шуурхай шийдвэрлэн ажиллалаа.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах сэрэмжлүүлэг мэдээг орон нутгийн [www.khovdtimes.mn](http://www.khovdtimes.mn), [www.khovdnews.mn](http://www.khovdnews.mn), [www.newkhovd.mn](http://www.newkhovd.mn), [www.khoa.nema.gov.mn](http://www.khoa.nema.gov.mn), [www.khovd.boet.gov.mn](http://www.khovd.boet.gov.mn) сайтууд, Ховд, Олон ястан, Жаргалант, ЭКО телевиз, Ховдын мэдээ, Ховдын толь зэрэг хэвлэл мэдээллийн сувгууд, чанга яригчаар өдөр бүр 3

удаагийн давтамжтайгаар нийт 122 удаа нэвтрүүлж иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг хурдан шуурхай хүргэж байна.

Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 31 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед тусгаарлан ажиллах зорилгоор Ховд их сургуулийн дотуур байр, Өргөө, Цамбагарав, Боорж, Минж, Роял, Велл зочид буудлуудтай тусгаарлан ажиглах байраар хамтран ажиллах гэрээг байгуулан мэргэжлийн байгууллагууд хяналт тавин ажиллаж байна

Зоонозын өвчин судлалын төвийн алба хаагчид шинжилгээ хийгдсэн газар, Жаргалант сумын Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлэг, “Ховд Жулиа” ХХК-иуд халдвар нь батлагдсан иргэний явсан маршрут, хүнсний дэлгүүр, тээврийн хэрэгсэл, орон сууцны орц, эмийн сан, албан байгууллагын 522 объектын нийт 683065 м<sup>2</sup> талбайд эцсийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ

Улаанбаатар хот болон бусад аймгаас орон нутагтаа ирэх, буяны ажил, албан томилолт, хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, өвс тэжээлийн тээвэрлэлт тухай хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт холбогдох бичиг баримтуудыг цахимаар хүлээн авч судлан шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүлээн авах зөвшөөрөл албан бичгээр гаргаж шуурхай шийдвэрлэж ажилласан. Хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын алба хаагчдад тухай бүрт холбогдох дүрэм журмын талаар мэдээллийг танилцуулж, буяны ажилд оролцох иргэдийн тоонд хяналт тавьж ажиллалаа.

Төв орон нутгийн Онцгой комиссоос олгосон зөвшөөрлийн дагуу орон нутагт зорчиж буй иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, дамжин өнгөрөх үед нь Дарви, Эрдэнэбүрэн, Мянгад сумдын хяналтын цэгүүдэд тээврийн хэрэгслийн жолооч болон зорчигчийн бүхээгний хаалгыг лацдаж, аймгийн нутаг дэвсгэрээс гарахад нь лацыг шалган ажиллаж байна.

**Хоёр: Нутгийн удирдлага зохион байгуулалтын хүрээнд:** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 36 өргөдөл бичгээр хүлээн авч, 34 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 4 өргөдөл бичгээр хүлээн авч, 3 өргөдлийг шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 92.5 хувьтай байна.

Засгийн газрын 1111 төвд тайлант дүгээр сард гомдол 2 ирж хугацаанд нь шийдвэрлэв.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 30 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 30, гомдол 9, санал хүсэлт 21 бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 16 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 53.3 хувьтай байна. Үүнд боловсролын асуудлаар 1, хууль эрх зүй 3, орчны эрүүл ахуйн асуудлаар 3, Эрүүл мэндийн асуудлаар 2, Цахилгаан эрчим хүчний асуудлаар 2, бусад асуудлаар 19 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 16, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа гомдол 14 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл, санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр 632 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 372 иргэнд нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр 974 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллав.

**Гурав: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:** Орон нутгийн төсвийн байгууллагуудын 4 дүгээр сард улсын төсвийн санхүүжилтээр 19541,1 сая төгрөг ирэхээс бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 2631,7 сая төгрөгийн санхүүжилтээс 973,3 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 5159,6 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 2710,7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 8941,2 сая төгрөг, цэцэрлэг 4575,9 сая төгрөг, хүн эмнэлэг 2353,6 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 163,8 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 173,5 сая төгрөг тус тус олголоо.

Орон нутгийн төсвийн байгууллага 140, төсвөөс гадуурх байгууллага 13, төсөл, сангийн 38, ОНӨААТҮГ-ын 12, бусад 4 нийт 207 байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын байгууллагаар

баталгаажуулсныг хүлээн авч хянан “Е” цахим тайлангаар нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хянуулж байна.

2020 оны жилийн эцсийн тайлангаар 10 байгууллагад “Итгэл” үзүүлж, 144 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 100 байгууллага “Зөрчилгүй” 41 байгууллага, “Хязгаарлалттай” 2 байгууллага, “Сөрөг” 1 байгууллага “Татгалзсан” дүгнэлттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 4 дүгээр сарын 1-22-ны өдрүүдэд аймгийн Аудитын газраар баталгаажуулан “Зөрчилгүй санал” дүгнэлт өглөө. Аймгийн 2021 оны 4 дүгээр сарын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулахаар аймгийн хэмжээнд “SMS” үйлчилгээг нэвтрүүлж төсвийн захирагч, нягтлан бодогч нарт мессежээр чиглэл хүргүүлж, шилэн дансны мэдээллийг хугацаандаа бүрэн оруулахыг анхааруулан ажилласнаар аймгийн хэмжээнд нийт 17 сум, 152 байгууллагын 7044 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 5849 мэдээллийг байршуулсан, нийт байршуулсан 5849 мэдээллийн 5237 мэдээлэл хуулийн хугацаандаа, 612 мэдээлэл хугацаа хоцорсон цаашид хугацаа хоцроохгүй байх чиглэл өгч байна. Төвлөрүүлэн захирагч болон төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулсан дундаж үзүүлэлт 4 дүгээр сарын 14-ны байдлаар 83 хувьтай байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 1134 ширхэг зардлын ваучер бичиж, 8370,3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг зардлын ваучераар гүйцэтгэлээ.

Орон нутгийн төсвийн 2021 оны 1 дүгээр улирлын урьдчилсан гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж цаашид анхаарах асуудлын чиглэл гаргаж танилцуулга бичиж боршур ном болгон 10 хувь олшруулж аймгийн удирдлагуудад хүргүүлэв.

Аймаг, сумдын 36 төсөвт байгууллагуудаас ирүүлсэн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг хянаж, 15,2 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээлээ. Хувь хүний орлогын албан татварын 2020 оны буцаан олголтыг 1153 иргэнд 590.9 сая төгрөгийг 100 хувь олгосон.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-баланс системд цахим хэлбэрээр хүлээн авах, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулах зэрэг аргагүйгээр ханган ажиллаж, хуулийн хугацаанд нийт 1832 аж ахуйн нэгж байгууллагын тайланг 86.9%-тайгаар 1592 ААНБ-ын тайланг хүлээн авч нэгтгэн Сангийн яаманд хүргүүлээ.

Үүнд 4 төрийн өмчийн үйлдвэрийн газар, 10 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 958 ХХК, 363 улсын бүртгэлтэй нөхөрлөл, 174 улсын бүртгэлтэй хоршоо, 69 олон нийтийн болон төрийн бус байгууллага, 3 Хувьцаат компани, 1 МҮЦБ, 2 банк бус санхүүгийн байгууллага, 8 хадгаламж зээлийн хоршооны тайланг хүлээн авч баталгаажууллаа.

Аймгийн ААНБ-ууд 2020 онд нийт 340435.4 сая төгрөгийн борлуулалтын ажил үйлчилгээ үзүүлэн 329545.7 сая төгрөгийн зардал гаргаж, орлого нь өмнөх оноос 4535,5 сая төгрөгөөр өссөн байна.

График 3




2020 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлангийн борлуулалтын орлого болон ААНОАТ-ын тайлангийн борлуулалтын орлого хоёрын зөрүү 2,1 тэрбум байна. Ашиг алдагдлыг өмчийн хэлбэр тус бүрээр нь авч үзэхэд ТӨҮГ болон ТББ-уудын нэгтгэл алдагдалтай, бусад нь ашигтай байна. Нийт дүнгээр урьд онуудтай харьцуулахад ашиг өсч, алдагдал нэлээн буурсан байна. Өөрөөр хэлбэл 2019 онд 2 тэрбумын ашигтай ажилласан бол 2020 онд 10,1 тэрбумын ашигтай ажиллаж ашиг 8,1 тэрбумаар өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 3 жилд ТӨҮГ-уудын алдагдал тасралтгүй буурсан үзүүлэлттээс харахад ОНӨҮГ-уудын хувьд 2018 онд алдагдалтай байсан бол 2019, 2020 онуудад ашигтай ажилласан байна. Хувийн хэвшлийн ААНБ-ын ашиг 2020 онд 7219,8 сая төгрөгөөр нэмэгджээ. МҮЦБ, ХЗХ, ББСБ-ууд сүүлийн 3 жил дараалан ашигтай ажилласан ба өмнөх жилүүдэд ашигтай ажиллаж байсан ТББ-ууд алдагдалтай ажиллажээ.


График 4

/сая төгрөгөөр/





Татварын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан судалгааг төсөв бүрээр графикаар харуулав.

Сүүлийн 3 жилийн 1-р улирлын байдлаар /мян. төгрөгөөр/




Дээрхи графикуудаас үзвэл жил бүр татварын төлөвлөгөө, гүйцэтгэл өссөн байна.



2021 оны 1-р улирлаар төлөвлөгөө тасарч байгаа шалтгаан нь урьд оноос төлөвлөгөө 1.6 тэрбумаар нэмэгдэн COVID-19 цар тахал дотоодод тархаж эдийн засаг хумигдсантай холбоотой байна.

Тайлант 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар орон нутгийн төсвийн орлогод 2974,0 сая төгрөг орж, төлөвлөгөө 878,3 сая төгрөгөөр буюу 22,8 хувиар, үүнээс татварын орлогод 2722.6 сая төгрөг орж төлөвлөгөө 740.9 сая төгрөгөөр буюу 23.6 хувиар, татварын бус орлогод 250,7 сая төгрөг оруулж төлөвлөгөө 82,5 сая төгрөгөөр буюу 24,8 хувиар тус тус тасарсан байна.

Төсвийн орлогын гүйцэтгэл /сая төгрөгөөр/



Орон нутгийн төсвийн байгууллагуудын 3 дугаар сарын байдлаар улсын төсвийн санхүүжилтээр 14819.3 сая төгрөг ирэхээс бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 825.5

сая төгрөгийн санхүүжилтээс 538.3 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 3897.5 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 1882.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 6674.9 сая төгрөг, цэцэрлэг 3465.5 сая төгрөг, хүн эмнэлэг 1765.2 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 123.0 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 133.1 сая төгрөг тус тус олголоо.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 16675,3 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 4571,5 сая төгрөгөөр, үүнээс орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зарлага 3249,5 сая төгрөг хүрч, 2694,1 сая төгрөгөөр, орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын зарлага 13425,8 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 1877,4 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зарлага 538,3 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 287,2 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэн урьдчилсан дүнтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 538,3 сая төгрөг, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 99,7 сая төгрөг гарч, Орон нутгийн хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах сан, замын сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл гараагүй байна.

Орон нутгийн төсвийн өр 313,9 сая , авлага 188,3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 109,3 сая төгрөгөөр, авлага 1087,6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Энэ улирлын байдлаар улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 1152,2 сая төгрөг оруулахаас 1599,3 сая төгрөг оруулж төлөвлөгөө 447,1 сая төгрөгөөр буюу 138,8 хувиар биелүүлсэн байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагуудын өөрийн орлогод 0,6 сая төгрөг орж, төлөвлөгөө 0,5 хувийн биелэлттэй байна.

Боловсролын салбарын төсвийн зарлага 11371,6 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1584,3 сая төгрөгөөр дутуу гарч, өр 223,2 сая, авлага 5,4 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 95,2 сая төгрөгөөр, авлага 26,4 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлага 1759,7 сая төгрөг



болж төлөвлөснөөс 255,3 сая төгрөгөөр дутуу гарч, өр 6,9 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 82,2 сая төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн нийт өрийг эдийн засгийн ангиллаар задлахад ажиллах хүчинтэй холбогдсон зардал 99,3, тогтмол зардал 157,4, хангамж, бараа материалын зардал 51,3 сая, норматив зардал 6,0 сая төгрөгийн өр ихэнх хувийг эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мөст, Алтай сумын төсөвт байгууллагуудын 2019, 2020 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний А/192 дугаар захирамжийн дагуу гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал, хязгаарлалтын дэглэмийн үед үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын хоол хүнс, шатахуун, тусгаарлах байр, хяналтын цэгүүдтэй холбоотой зардал, эм, эмнэлэгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, түргэвчилсэн тест, хамгаалах хувцас, хэрэгсэл зэрэг бараа материалын худалдан авалт зарцуулалтанд санхүүгийн аудит хийх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсаны дагуу Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төвийн 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 15-ны хоорондох нэмэлт дансны баримтанд санхүүгийн хяналт, шалгалтыг хийж ажиллалаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР